



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/1767

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "г", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтууд, аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит III хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 22 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газрын автомашинд шаардлагатай байгаа сэлбэгийн үнэ 2.624 000 /хоёр сая зургаан зуун хорин дөрвөн мянган/ төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй

2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналт хэрэгжүүлэх төслийн багийн болон газрын албан хаагчдын хөдөө орон нутагт ажиллах унааны бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-т үүрэг болгосугай

ДАРГА



Л. ГАНБОЛД

02 1533

d:zahiramj